



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 107


Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн
гишүүнээр томилуулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн санал, дүгнэлт, мөн Байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 8/6007 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Шилагарьдын Солонгыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосугай.

ДАРГА



М.ЭНХБОЛД

0000000342



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16

E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018.05.22 № 8/6007

танай _____-ны № _____-т

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд
нэр дэвшүүлсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж, Шилагарьд овогтой Солонгыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг гарган Танд хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



0000001988

ТАНИЛЦУУЛГА

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч/

- 1.Овог, нэр: Шилагарьдын СОЛОНГО
- 2.Хэзээ, хаана төрсөн: 1962 онд Улаанбаатар хотод.
- 3.Нас, хүйс: 56 настай, эмэгтэй.
- 4.Үндэс угсаа: Халх.
- 5.Ам бүлийн байдал: Нөхөр, хүүхдийн хамт амьдардаг.
- 6.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:
- 1979 онд Нийслэлийн 23 дугаар сургууль;
 - 1984 онд Москвагийн Их сургууль;
 - 1994 онд Тайваньд Зах зээлийн худалдааны хууль, тогтоомжийн чиглэлээр;
 - 2000 онд Австри улсад Захиргааны шийдвэрийн нөлөөллийн чиглэлээр;
 - 2005 онд ХБНГУ-д Захиргааны ерөнхий хуулиар тус тус мэргэшил дээшлүүлсэн;
 - хуульч мэргэжилтэй, Гавьяат хуульч.
- 7.Ажилласан байдал:
- 1984-1992 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтэст мэргэжилтэн;
 - 1992-1994 онд Засгийн газрын Тамгын газарт дэс түшмэл, Тасгийн дарга;
 - 1994-2000 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт түшмэл, Засгийн газрын ахлах референт;
 - 2000-2008 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хуулийн хэлтсийн дарга;
 - 2008 оноос Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар ажиллаж байна. Төрийн албанд 34 жил ажиллсан.
- 8.Гадаад хэл:
- Орос, англи хэлтэй.



---ooOoo---